

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
САГ	Санхүүгийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ҮОМШӨ	Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
УБ	Улаанбаатар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	19
4. Менежментийн захидал	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.03.15 № 07/800
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Улсын авто замын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын авто замын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6-д "Улсын авто замын сан нь авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын, нийслэл, орон нутгийн авто замын сан нь аймаг, нийслэлийн Засаг даргын мэдэлд байна", 25 дугаар зүйлийн 25.1-д "Улсын авто замын сангийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

25.1.1.импортоор оруулж байгаа автомашины онцгой албан татварын 20-иос доошгүй хувь;

- 25.1.2.гадаадын зээл, тусламж, хандивын хөрөнгө;
25.1.3.улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;
25.1.4.олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам ашигласны төлбөр;
25.1.5.олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам дээр замын хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаарх хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль;
25.1.6.Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх олон улсын тээврийн хэрэгслээс авах төлбөр, хураамж;
25.1.7.авто замын зурвас газарт холбогдох зөвшөөрлийн дагуу үйлчилгээ эрхэлсний төлбөр гэсэн байна.

Гэтэл Улсын авто замын сан “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын бүтцэд “Төлбөр авах үйл ажиллагааны хэлтэс” нэрээр харьяалагдаж хуулийн дээрх заалтуудаас зөвхөн авто зам ашигласны төлбөр хураамжийг авч улсын төсөвт төвлөрүүлэх үүрэг хүлээж байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	267,027,324.93	4,745,409,600.94
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	252,880,943.93	226,569,848.93
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	252,880,943.93	226,569,848.93
33	АВЛАГА	-	361,163.41
335	Бусад авлага		361,163.41
3351	Байгууллагаас авах авлага	-	361,163.41
34	УРЬДЧИЛГАА	-	4,464,296,140.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	4,464,296,140.00
35	БАРАА МАТЕРИАЛ	14,146,381.00	54,182,448.60
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,617,649.99	6,740,918.60
354	Хангамжийн материал	12,528,731.01	47,441,530.00
35410	Бичиг хэргийн материал		4,608,930.00
35420	Аж ахуйн материал	464,000.01	464,000.01
35430	Сэлбэг хэрэгсэл	126,500.00	412,500.00
35470	Бусад хангамжийн материал	11,938,231.00	41,956,099.99
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,649,664,206.17	1,253,374,759.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,649,664,206.17	1,253,374,759.69
392	Биет хөрөнгө	1,649,664,206.17	1,253,374,759.69
39201	Барилга байгууламж	1,862,541,998.05	1,182,125,934.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	(393,687,908.28)	
39203	Авто-тээврийн хэрэгсэл	222,220,757.80	222,220,757.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	(222,220,757.80)	(222,220,757.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	364,075,300.00	364,075,300.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(200,972,399.79)	(309,286,266.46)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,205,550.00	33,225,550.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,498,333.81)	(16,765,758.70)
393	Биет бус хөрөнгө	-	-
39301	Програм хангамж	820,000.00	820,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(820,000.00)	(820,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,916,691,531.10	5,998,784,360.63
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,916,691,531.10	5,998,784,360.63
51	Засгийн газрын хувь оролцоо	1,916,691,531.10	5,998,784,360.63
512	Хуримтлагдсан үр дүн	1,916,691,531.10	5,614,233,003.62
51210	Өмнөх үеийн үр дүн	1,916,691,531.10	1,916,691,531.10
51220	Тайлант үеийн үр дүн	-	3,697,541,472.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		384,551,357.01
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,916,691,531.10	5,998,784,360.63

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	8,901,366,785.24	54,456,526,712.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,901,366,785.24	8,656,526,712.92
120	Нийтлэг татварын бус орлого	8,901,366,785.24	8,656,526,712.92
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	8,901,366,785.24	8,656,526,712.92
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,866,366,785.24	8,648,005,712.92
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	25,000,000.00	
140020	Бусад орлого	10,000,000.00	8,521,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	45,800,000,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	45,800,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	45,800,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	9,060,467,188.89	50,188,036,245.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,060,467,188.89	3,240,529,624.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,199,460,457.15	3,057,050,697.11
2101	Цапин хөлс болон нэмэгдэл урамшил	1,663,731,635.94	2,000,378,015.60
210101	Үндсэн цалин	1,663,731,635.94	1,997,627,403.48
210102	Нэмэгдэл		2,750,612.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	208,919,548.66	253,100,401.69
210201	Тэтгэврийн даатгал	142,955,720.86	171,043,472.26
210202	Тэтгэмжийн даатгал	16,575,126.32	22,347,881.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,321,535.93	16,020,933.02
210204	Ажилгүйдлийн даатгал	3,274,520.14	3,954,201.01
210205	Эрүүл мэндийн даатгал	32,792,645.41	39,733,913.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,873,468.00	113,700,814.36
210301	Гэрэл цахилгааны зардал	38,170,828.00	107,055,364.36
210302	Түлш, халаалтын зардал	6,672,500.00	6,645,450.00
210303	Цэвэр, бохир усны зардал	30,140.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	93,940,994.99	96,905,302.80
210401	Бичигхэрэг	3,328,159.00	4,334,358.00
210402	Тээвэр, шатахуун	72,122,868.00	70,568,764.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,013,615.00	7,323,757.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	66,000.00	88,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,742,570.00	8,456,131.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	7,667,782.99	4,539,080.00
210408	Бараа материал ақталсны зардал		1,595,212.80
	Нормативт зардал	4,765,500.00	60,942,300.00
210601	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,765,500.00	60,942,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	120,183,590.22	108,498,301.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	90,812,500.00	58,821,681.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	350,000.00	34,401,870.00
210604	Урсгал засвар	29,021,090.22	15,274,750.00

2107	Томилолт, зочны зардаг	17,804,300.00	17,036,800.00
210702	Дотоод албан томилолт	17,804,300.00	17,036,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,770,121,826.76	194,576,953.31
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,735,726,961.00	156,250,166.67
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,500,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	78,400.00	377,784.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	470,115.00	463,915.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,067,500.00	819,500.00
210808	Газрын төлбөр	1,293,500.00	5,408,069.04
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	24,919,350.76	31,235,518.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	275,119,592.57	211,911,808.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	77,627,424.17	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	197,492,168.40	211,911,808.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,861,006,731.74	183,478,927.46
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,392,641.00	15,038,197.00
213207	Тэтгэвэрт гаргахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,083,163.00	2,388,197.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	12,309,478.00	12,650,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,847,614,090.74	168,440,730.46
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,847,614,090.74	168,440,730.46
28	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		46,947,506,620.70
	Дотоод эх үүсвэрээр		46,947,506,620.70
223001	Бусад хөрөнгө		46,947,506,620.70
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(159,100,403.65)	4,268,490,467.65
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (5)	50,231,110.13	570,948,995.13
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	50,231,110.13	
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал		570,948,995.13
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН 6=4-5	(50,231,110.13)	(570,948,995.13)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(209,331,513.78)	3,697,541,472.52

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	8,866,366,785.24	54,456,526,712.92
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,866,366,785.24	8,656,526,712.92
120	Нийтлэг татварын бус орлого	8,866,366,785.24	8,656,526,712.92
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	8,866,366,785.24	8,648,005,712.92
120041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,866,366,785.24	8,648,005,712.92
120009	Бусад орлого	-	8,521,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	45,800,000,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	45,800,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	45,800,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,863,638,290.24	3,063,170,247.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,863,638,290.24	3,063,170,247.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,016,024,199.50	2,894,729,516.76
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,016,024,199.50	2,894,729,516.76
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,016,024,199.50	2,894,729,516.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,847,614,090.74	168,440,730.46
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,847,614,090.74	168,440,730.46
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,847,614,090.74	168,440,730.46
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,728,495.00	51,393,356,465.70
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		51,419,667,560.70
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		51,419,667,560.70
	Дотоод эх үүсвэрээр		51,419,667,560.70
223001	Бусад хөрөнгө		51,419,667,560.70
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6=4-5)		(51,419,667,560.70)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,728,495.00	(26,311,095.00)
ЭХ.ДТ	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	250,152,448.93	252,880,943.93
ЭХ.ДТ	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	252,880,943.93	226,569,848.93

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 01-р сарын 31- нээрх үлдэгдэл			2,126,023,044.88	2,126,023,044.88
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,126,023,044.88	2,126,023,044.88
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(209,331,513.78)	(209,331,513.78)
2019 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	0.00	-	1,916,691,531.10	1,916,691,531.10
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		-	1,916,691,531.10	1,916,691,531.10
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	384,551,357.01	-	384,551,357.01
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	3,697,541,472.52	3,697,541,472.52
2020 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	0.00	384,551,357.01	5,614,233,003.62	5,998,784,360.63

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	55,000,000,000.00	54,282,276,077.46	-717,723,922.54	98.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	55,000,000,000.00	54,282,276,077.46	-717,723,922.54	98.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,984,091,800.00	2,871,093,316.77	-112,998,483.23	96.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,200,164,885.00	2,000,739,179.01	-199,425,705.99	90.9
210101	Үндсэн цалин	1,197,652,547.39	1,094,613,359.41	-103,039,187.98	91.4
210102	Нэмэгдэл	1,002,512,337.61	906,125,819.60	-96,386,518.01	90.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	280,488,600.00	253,100,401.69	-27,388,198.31	90.2
210201	Тэтгэврийн даатгал	190,732,248.80	171,043,472.26	-19,688,776.54	89.7
210202	Тэтгэмжийн даатгал	22,439,087.80	22,347,881.44	-91,206.36	99.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,951,270.24	16,020,933.02	-1,930,337.22	89.2
210204	Ажилгүйдлийн даатгал	4,487,817.56	3,954,201.01	-533,616.55	88.1
210205	Эрүүл мэндийн даатгал	44,878,175.60	39,733,913.96	-5,144,261.64	88.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,900,000.00	113,700,814.36	6,800,814.36	106.4
210301	Гэрэл цахилгааны зардал	99,400,000.00	107,055,364.36	7,655,364.36	107.7
210302	Түлш халаалтын зардал	7,500,000.00	6,645,450.00	-854,550.00	88.6
210303	Цэвэр бохир усны зардал				
2104	Хангамж, бараа материалын зардал	93,820,000.00	98,897,496.67	5,077,496.67	105.4
210401	Бичиг хэрэг	6,680,000.00	7,907,580.00	1,227,580.00	118.4
210402	Тээвэр, шатахуун	72,000,000.00	71,068,070.00	-931,930.00	98.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,640,000.00	7,323,757.00	1,683,757.00	129.9
210404	Хог хаягдал устгах, цэвэрлэх	0.00	88,000.00	-88,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,500,000.00	8,534,409.67	3,034,409.67	155.2
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	4,000,000.00	3,975,680.00	-24,320.00	99.4
2105	Нормативт зардал	64,984,400.00	80,876,000.00	15,891,600.00	124.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	64,984,400.00	80,876,000.00	15,891,600.00	124.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59,980,000.00	114,418,760.00	52,418,760.00	190.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,000,000.00	34,215,000.00	4,215,000.00	114.1
210602	Тавилга эд хогшил	0.00	2,020,000.00	2,020,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	14,980,000.00	63,731,720.00	48,751,720.00	425.4
210604	Урсгал засвар	15,000,000.00	14,452,040.00	-547,960.00	96.3
2107	Томилолт, зочны зардал	17,000,000.00	17,036,800.00	36,800.00	100.2
210701	Дотоод албан томилолт	17,000,000.00	17,036,800.00	36,800.00	100.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	160,753,915.00	177,285,668.04	16,531,753.04	110.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн	130,000,000.00	127,238,700.00	-2,761,300.00	97.9

	бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж				
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,500,000.00	3,500,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	377,784.00	-22,216.00	94.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	463,915.00	463,915.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	22,000.00	-88,000.00	20.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	1,619,500.00	119,500.00	108.0
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,200,000.00	5,408,069.04	4,208,069.04	450.7
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх,бэлтгэх	23,580,000.00	38,655,700.00	15,075,700.00	163.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	0.00	-
210901	Бараа ажл үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	0.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,908,200.00	15,038,197.00	-870,003.00	94.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,908,200.00	15,038,197.00	870,003.00	94.5
213207	Тэтгэвэрт гарахад нэг удаагийн мөнгөн тэтгэмж	3,000,000.00	2,388,197.00	611,803.00	79.6
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал, урамшуулал	12,908,200.00	12,650,000.00	258,200.00	98.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	52,000,000,000.00	51,411,182,760.70	588,817,239.30	98.9
223001	Бусад хөрөнгө	52,000,000,000.00	51,411,182,760.70	588,817,239.30	98.9
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	55,000,000,000.00	54,448,005,712.92	551,994,287.08	99.0
31	Улсын төсвөөс санхүүжих	40,000,000,000.00	45,800,000,000.00	-5,800,000,000.00	114.5
310001	Улсын төсвөөс санхүүжих	40,000,000,000.00	45,800,000,000.00	-5,800,000,000.00	114.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	15,000,000,000.00	8,648,005,712.92	6,351,994,287.08	57.7
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,000,000,000.00	8,648,005,712.92	6,351,994,287.08	57.7
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	158	228		
620001	Удирдах ажилтан	20	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	138	4		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ		223		
650010	Гэрээний ажилтан		223		

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		23,600,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		23,600,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		23,600,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		
2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		23,600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		
2132	Бусад урсгал шилжүүлэг		
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Бусад хөрөнгө		
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		
31	Улсын төсвөөс санхүүжих		
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
	Бусад орлого		
4	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		250,150,248.93
5	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		226,550,248.93

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын авто замын сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Р.Буд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төлбөр хураамж авах үйл ажиллагааны онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөн ажиллах, улсын бүртгэлийн гэрчилгээнд сангийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тусган бүртгүүлэх, үндсэн хөрөнгө, бараа материалын хөрөнгийг зөв ангилж бүртгэх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 23-наас 2021 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Ашид баланс аудит” ХХК-ийн ахлах аудитор Д.Гандолгор, аудитор М.Баярмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Улсын авто замын сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 2 дугаар сарын сарын 05-ны өдрийн 01/75 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Улсын авто замын сангийн хуулиар хүлээсэн чиг үүргийн нэг нь олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчсон тээврийн хэрэгслээс авто зам ашигласны төлбөр хураамж авах үйл ажиллагааг зохион байгуулах явдал юм.

Улсын авто замын сангийн үйл ажиллагааны чиглэлийг Авто замын тухай хуулийн 24, 25 дугаар зүйлд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- 24.3-т “Улсын авто замын сангийн хөрөнгөөр олон улс, улсын чанартай авто замын, нийслэл, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг тус тус санхүүжүүлнэ”
- 24.5-д “Авто замын сангаас авто замын засвар, арчлалтын ажлыг хариуцсан байгууллагын үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх, судалгаа шинжилгээний ажил хийх, техник технологийг шинэчлэх, хөндлөнгийн хяналт тавих, хөдөлгөөнт эргүүл ажиллуулах, мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх, авто замын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг санхүүжүүлнэ”

Тайлант хугацаанд авто замын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Улсын авто замын сан санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, “санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлал”-ын дагуу санхүүгийн тайлан бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд Зам, тээврийн хөгжлийн яамны болон “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Улсын авто замын сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад өөрчлөгдөөгүй болно.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 8,901,366.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 89,013.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 54,456,526.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 544,565.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Улсын авто замын сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,082,092.9 мянган төгрөгөөр буюу 3.1 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урьдчилгаа, бараа материал болон үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	252,880.9	226,569.8	-26,311.1
Авлага	0.0	361.2	361.2
Урьдчилгаа	0.0	4,464,296.1	4,464,296.1
Бараа материал	14,146.4	54,182.4	40,036.0
Үндсэн хөрөнгө	1,649,664.2	1,253,374.8	-396,289.4
Нийт хөрөнгө	1,916,691.5	5,998,784.4	4,082,092.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,916,691.5	5,998,784.4	4,082,092.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,916,691.5	5,998,784.4	4,082,092.9

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 226,569.8 мянган төгрөг болж 26,311.1 мянган төгрөгөөр буурсан нь 2018 оны давсан орлогоос санхүүжих төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтээс 23,600.0 мянган төгрөгийг зарцуулж, өмнөх оны Голомт банкны үлдэгдэл 2,711.1 мянган төгрөгийг төрийн санд төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Авлага данс эхний үлдэгдэлгүй байсан ба оны эцэст 361.2 мянган төгрөг болсон нь хувь хүний орлогын албан татварын илүү төлөлтөөс шалтгаалсан байна.

Урьдчилгаа данс эхний үлдэгдэлгүй байсан бол тайлант оны эцсийн үлдэгдэл 4,464,296.1 мянган төгрөг болсон нь замын сангийн хөрөнгөөр шинээр 8 төлбөр авах цэг барих, 4 төлбөр авах цэгт авто пүү суурилуулах, Налайх-Тэрэлжийн төлбөр авах цэгийг өргөтгөх, Түргэний гүүрний төлбөр авах цэг барих, шинээр баригдах төлбөр авах цэгийн зураг төслийг шинэчлэн боловсруулах зэрэг ажлуудад зарцуулагдсан хөрөнгийг бүртгэснээс шалтгаалжээ.

Дээрх хийгдсэн ажлуудаас 2 төлбөр авах цэг барих, 2 авто пүү суурилуулах ажил дуусаагүй ба бусад хөрөнгийн хувьд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас үндсэн хөрөнгөөр бүртгэх тогтоол шийдвэр гараагүй тул урьдчилж гарсан зардал дансанд бүртгэсэн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 54,182.4 мянган төгрөгт хүрч 40,036.0 мянган төгрөгөөр өссөн нь шинээр ашиглалтад орох төлбөр авах цэгүүдийн ажилчдын ажлын гутал, хувцас 19,933.7 мянган төгрөг, улс орон даяар ковид-19 цар тахал халдварт өвчин гарсантай холбогдуулан ариутгал, хамгааллын хэрэгслийн нөөцийг хот хоорондын зам хаасантай холбоотой төлбөр авах цэгүүдэд олгож чадаагүй үлдэгдэл 10,370.1 мянган төгрөг, бичиг хэргийн материал 4,608.9 мянган төгрөг, талон /үнэт цаас/-ны үлдэгдэл 5,123.3 мянган төгрөг байгаатай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,253,374.8 мянган төгрөг болж 396,289.4 мянган төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2020 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн А-1/1307 дугаар албан бичгийн дагуу 2018 оны хөрөнгийн дахин үнэлгээнд хамрагдаагүй 24 төлбөр авах цэгийн барилга, байгууламжид дахин үнэлгээ хийлгэж 384,551.4 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдэл, 570,949.0 мянган төгрөгийн дахин үнэлгээний хорогдол үүссэнээс барилга байгууламж 186,397.64 мянган төгрөг, тайлант хугацааны элэгдлийн зардал 211,911.8 мянган төгрөг, нийт 398,309.44 мянган төгрөгөөр хасагдсанаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,998,784.4 мянган төгрөг болж 4,082,092.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн ашиг 3,697,541.5 мянган төгрөг, мөн төлбөр авах цэгүүдийн барилга байгууламжид хийсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 384,551.4 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Улсын авто замын сангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 54,456,526.7 мянган төгрөг болж өмнөх оноос 45,555,159.9 мянган төгрөгөөр буюу 6.1 дахин, нийт зардал өмнөх оноос 41,127,569.0 мянган төгрөгөөр буюу 5.5 дахин өссөн нь өмнөх онд улсын төсвөөс зөвхөн урсгал үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлдэг байсан бол тайлант оноос олон улс, улсын чанартай авто замын засвар, арчлалтын зардлыг Засгийн газрын 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 312 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу санхүүжүүлэх болсонтой холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2020 оны төсвийн төсөлд олон улс, улсын чанартай авто зам ашигласны төлбөр хураамжаас бүрдүүлэх орлогыг 8,500,000.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,397,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн нийт зарлагын төсвийн төслөөс 397,000.0 мянган төгрөгөөр бууруулж 3,000,000.0 мянган төгрөгөөр баталсан нь анх төлөвлөхдөө 8 төлбөр авах цэг шинээр ашиглалтад орж, үйл ажиллагааг нь эхлүүлэхээр төлөвлөж цалингийн зардлыг нэмэгдүүлж тооцсон боловч ЗТХЯ-наас төлбөр авах үйл ажиллагааг

цахимжуулах ажил хийгдэж байгаатай уялдуулан цалингийн зардлыг бууруулсантай холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого болох олон улс, улсын чанартай авто зам ашигласны төлбөр хураамжаас бүрдүүлэх орлогыг өмнөх оны гүйцэтгэлийн түвшин буюу 8,500,000.0 мянган төгрөгөөр тооцож төлөвлөсөн боловч дээд шатны байгууллагаас орлогын төлөвлөгөөг 2 дахин нэмэгдүүлж 15,000,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 55,000,000.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 40,000,000.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 15,000,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 45,800,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлогоор 8,648,005.7 мянган төгрөг, нийт 54,448,005.7 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлж, бараа, ажил үйлчилгээний зардалд 2,871,093.3 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 51,411,182.8 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 168,440.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 54,282,276.1 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь бараа, ажил үйлчилгээний зардлыг 112,998.5 мянган, хөрөнгийн зардлыг 588,817.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Авто замын тухай хуулийн 30 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны “Журам батлах, төлбөрийн хэмжээ тогтоох тухай” 103 дугаар тогтоол, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 274 дүгээр тушаалыг мөрдлөг болгон олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс төлбөр, хураамж авах үйл ажиллагааг 20 төлбөр авах цэгээр дамжуулан зохион байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуульд зааснаар тайлант онд 15,000,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 8,648,005.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөний биелэлт 57.6 хувьтай байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Улсын төсвөөс санхүүжих	40,000,000.0	45,800,000.0	5,800,000.0	14.5%
Үндсэн үйл ажиллагааны орлого	15,000,000.0	8,648,005.7	6,351,994.3	42.4%
Нийт дүн				

Орлогын төлөвлөгөө тасарсан нь дараах хэд хэдэн шалтгаантай байна. Үүнд:

- 2019 оны орлогын төлөвлөгөө 6,500,000.0 мянган төгрөг, гүйцэтгэлээр 8,866,366.8 мянган төгрөг байсан бол тайлант оны орлогын төлөвлөгөө өмнөх оноос 2 дахин нэмэгдэж 15,000,000.0 мянган төгрөг болсон.
- Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын их засвар шинэчлэлтийн ажил дуусаагүйтэй холбоотой УБ-Дархан чиглэлийн зам дагуух Баруун туруун, Дарханы төлбөр авах цэгүүд ажиллах боломжгүй болсон.
- Мөн УБ-Дархан чиглэлийн авто замын их засвар, шинэчлэлийн ажил хойшлогдсонтой холбоотой тус чиглэлд байрлах Эрдэнэтийн Хангалын гүүр,

Сэлэнгийн Дулаанхаан, Булганы Гуртын гүүрийн төлбөр авах цэгүүдийн орлого буурсан.

- Улс орон даяар ковид-19 цар тахал халдвар гарсантай холбоотой улсын онцгой комиссоос сар шинийн баярын оргил ачааллын үед хөдөлгөөнийг хаасан, мөн 11 дүгээр сарын 12-ноос хөдөлгөөн хаасан.
- Ковид-19 цар тахал халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үүднээс улсын онцгой комиссоос хурдны замын хөдөлгөөнийг хааснаас үүдэн Хөшигийн хөндийн төлбөр авах цэг 3 дугаар сараас эхлэн орлого төвлөрүүлээгүй зэрэг нь орлого буурахад нөлөөлсөн байна.

Улсын төсвийн санхүүжилт батлагдсан төлөвлөгөөнөөс 5,800,000.0 мянган төгрөгөөр хэтэрсэн нь замын хураамжийн орлогын төлөвлөгөөний тасалдлын хэмжээгээр олон улс, улсын чанартай авто замын засвар арчлалтын зардлыг санхүүжүүлэх болсонтой холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 2019 оны орлогын төлөвлөгөө давуулан биелүүлсний үлдэгдэл 23,600.0 мянган төгрөгийг авто замын засвар арчлалтын зардлын санхүүжүүлэлтэд зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Улсын авто замын сан бие даасан хуулийн этгээдийн статусгүй, "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын харьяа нэгж тул Шилэн дансны цахим хуудсанд нэвтрэх эрх олгогдоогүй, ЗТХЯ-ны аппаратын цахим хуудсанд давхар мэдээлдэг байна.

Гэвч Зам, тээврийн хөгжлийн яамны шилэн дансны цахим хуудсанд "Улсын авто замын сан" нэрээр ил тод харагдахгүй зөвхөн замын сангийн 100900028054 тоот дансны дугаараар харагддаг байна.

Улсын авто замын сан Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлд заасан тухайн жилийн төсөв, сар, улирлын төсвийн гүйцэтгэл, төсвийн хэтрэлт, хэмнэлт, түүний шалтгааны тайлбар мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Тайлант хугацаанд оруулбал зохих 26 мэдээллээс хугацаандаа оруулсан 19 мэдээлэл, хугацаа хоцроосон 7 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5,148.3 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 6 зөвлөмжөөс 5 нь 100 хувийн биелэлттэй, харин 1 зөвлөмж буюу “татварын тайланг тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-аас тусдаа бэлтгэж, төлбөрийн баримтыг уг байгууллагаас өөр регистрийн дугаараар авах, зам ашигласны төлбөрт үнэт цаасны оронд төлбөрийн баримт өгч хэвших, эдгээр асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх” гэсэн зөвлөмжийн биелэлт 80 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	6	5,148.3	5	5,148.3	1	-	80.0
Нийт дүн	6	5,148.3	5	5,148.3	1	-	80.0

/мянган.төг/

Хэрэгжээгүй дээрх зөвлөмжийн тухайд Улсын авто замын сан бие даасан хуулийн статустай болсон тохиолдолд зөвлөмж хэрэгжиж өөрийн регистрээр тайлан гаргах болон төлбөрийн баримт /ебаримт/ олгох боломжтой болно.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,471,213.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 4,464,296.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 216.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 6,701.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч, 1 албан шаардлага хүргүүлээ.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Тайлант онд шинээр баригдсан 6 төлбөр авах цэг, баригдаж дуусаагүй 2 төлбөр авах цэг, нийт 8 барилга байгууламжийг ТӨБЗГ-аас зөвшөөрөл гараагүй байгаа шалтгаанаар бүртгэлд авалгүй шууд зарлага болгож, улмаар үр дүнгийн тайлангаар 766,754.7 мянган төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Аудитын явцад дээрх 8 төлбөр авах цэгийн барилга байгууламжид гарсан нийт 4,464,296.1 мянган төгрөгийн зардлыг "урьдчилж гарсан зардал" дансанд бүртгэж Санхүүгийн байдлын болон Үр дүн, Өмчийн өөрчлөлтийн тайланд залрууллаа.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 6,917.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 216.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. 2020 оны 11 дүгээр сард "Төлбөр авах үйл ажиллагааны хэлтсийн дарга Б.Болортуяа 12 хоног, мэргэжилтэн Д.Дариймаа 8 хоног, 12 дугаар сард хэлтсийн дарга Б.Болортуяа 7 хоног ажилласан байхад хоол, унааны зардалд бүтэн ажилласнаар тооцож нийт 216.0 мянган төгрөг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн хуулийн 23 дугаар зүйлийн 23³.2-д "...ажил олгогчоос тодорхой ажил, үүргийг биечлэн гүйцэтгүүлж, гүйцэтгэсэн ажлын хэмжээ, ажилласан цагт нь тохирсон цалин хөлсийг тухай бүр тооцож олгох" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Авто замын сан бие даасан хуулийн этгээдийн статусгүй, "Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын харьяа нэгж тул Шилэн дансны цахим хуудсанд нэвтрэх эрх олгогдоогүй, ЗТХЯ-ны аппаратын цахим хуудсанд давхар мэдээлдэг байна.

Гэвч Зам, тээврийн хөгжлийн яамны шилэн дансны цахим хуудсанд зөвхөн замын сангийн 100900028054 тоот дансны дугаараар харагдахаас "Улсын авто замын сан" нэрээр ил тод харагдахгүй байна.

Тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 26 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 6,701.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Төлбөр авах цэгийн барилга, байгууламж болон олон улс, улсын чанартай авто замын засвар арчлалтын ажлын тендер шалгаруулалт, санхүүжилтийг дараагийн аудитаар дэлгэрэнгүй үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Хуульд заасны дагуу Улсын авто замын санг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдэлд бүрэн шилжүүлэх, эсхүл "Төлбөр хураах цэг"-ийг бие даасан улсын төсөвт аж ахуйн нэгж болгон зохион байгуулах эрх зүйн орчныг судалж, санал боловсруулан холбогдох байгууллагуудад асуудлыг танилцуулан шийдвэрлүүлэх арга хэмжээ авах хэрэгтэй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Улсын авто замын сан бие даасан хуулийн этгээдийн статусгүй, 5645913 тоот регистрийн дугаартай “Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ”-ын улсын бүртгэлийн гэрчилгээгээр үйл ажиллагаагаа явуулдаг боловч энэхүү гэрчилгээнд “олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчсон тээврийн хэрэгслээс авто зам ашигласны хураамж авах үйл ажиллагааг зохион байгуулах” гэсэн сангийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тусгаагүй нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т “хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлтийн бүртгэлтэй байна”, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3-т “дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Хууль хэрэгжихгүй, Эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байх

1.3. Өгсөн зөвлөмж:

“Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ”-ын улсын бүртгэлийн гэрчилгээнд авто замын сангийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тусган бүртгүүлэх

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн бүртгэлд бараа материалын шинжтэй 740.3 мянган төгрөгийн, бараа материалын бүртгэлд үндсэн хөрөнгийн шинжтэй 5,961.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.16-д “бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг мөрдөнө”, 4.29-д “үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, тэдгээрийн дансны үнэ, элэгдэл шимтгэлийн хэмжээг тодорхойлох, дахин үнэлгээ зэрэг нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө”-ийг дагаж мөрдөнө” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

УСНББОУС зөрчигдөх, Үнэн зөв байх, Үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байх

2.3. Өгсөн зөвлөмж:

Зөрчлийг давтан гаргахгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Сангийн сайдын баталсан зааврын дагуу үндсэн хөрөнгө болон бараа материалыг зөв ангилж бүртгэж байх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3. Балансын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Төлбөр хураах үйл ажиллагааны хэлтэс “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын бүтцэд харьяалагдаж тусдаа санхүүгийн тайлан гаргадаг боловч үйл ажиллагааны онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль, тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

УСНББОУС-тай нийцэхгүй, хууль хэрэгжихгүй байх, санхүүгийн үйл ажиллагаа алдагдах

3.3. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөж ажиллах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Улсын авто замын сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/11/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	Улсын авто замын сан		мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Улсын авто замын сан нь бие даасан хуулийн этгээдийн статусгүй, "Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ"-ын улсын бүртгэлийн гэрчилгээгээр үйл ажиллагаагаа явуулдаг боловч энэхүү гэрчилгээнд замын сангийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тусгаагүй.	-	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Р.Буд Ц.Мөнхтуяа
2	Үндсэн хөрөнгийн бүртгэлд бараа материалын шинжтэй 740.3 мянган төгрөгийн, бараа материалын бүртгэлд үндсэн хөрөнгийн шинжтэй 5,961.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэсэн.	6,701.8	Зөвлөмж өгөх		
3	Төлбөр хураах үйл ажиллагааны хэлтэс "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын бүтцэд харьяалагдаж тусдаа санхүүгийн тайлан гаргадаг боловч үйл ажиллагааны онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй.	-	Зөвлөмж өгөх		
4	Зарим нэр бүхий ажилтнуудад ажилласан хоног дутуу байхад хоол, унааны зардалд бүтэн ажилласнаар тооцож илүү мөнгө олгосон.	216.0	Төлбөрийн акт тогтоох		
5	Авто замын сан бие даасан шилэн дансны цахим хуудасгүй, яамны цахим хуудсанд давхар мэдээлдэг боловч зөвхөн замын сангийн дансны дугаараар харагдахаас "Улсын авто замын сан" нэрээр ил тод харагддаггүй, тайлант онд шилэн дансанд 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.	-	Албан шаардлага хүргүүлэх		
ДҮН		6,917.8			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 15

№ 316/А0170067

Улаанбаатар хот

Сэтгүүл-2021/11/СТА-ЗГТС.

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын авто замын сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын авто замын сан бие даасан шилэн дансны цахим хуудасгүй, Зам, тээврийн хөгжлийн яамны цахим хуудсанд давхар мэдээлдэг боловч зөвхөн замын сангийн 100900028054 тоот дансны дугаараар харагдаж, харин "Улсын авто замын сан" нэрээр ил тод харагддаггүй, тайлант жилийн төсөв, сар, улирлын төсвийн гүйцэтгэл, төсвийн хэтрэлт, хэмнэлт, түүний шалтгааны тайлбар нийт оруулбал зохих 26 мэдээллээс 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 4.1.4-д "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Бие даасан шилэн дансны цахим хуудас нээж, шилэн дансанд оруулбал зохих мэдээллүүдийг хугацаанд нь, ил тод, бүрэн оруулж, дээрх зөрчлийг арилган, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын авто замын сангийн захирал Р.Буд, нягтлан бодогч Ц.Мөнхтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Д.ГАНДОЛГОР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2021\03\15auditin 2-R Газар87.Docx

001080316



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2021 оны 03 дугаар сарын 15 № 77/А0170067
САГ-2021/11/СТА-3ГТС

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын авто замын сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд нэр бүхий 2 ажилтанд хоол унааны зардал 216000.00 /хоёр зуун арван зургаан мянга/ төгрөг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн хуулийн 23 дугаар зүйлийн 23³.2-д "...ажил олгогчоос тодорхой ажил, үүргийг биечлэн гүйцэтгүүлж, гүйцэтгэсэн ажлын хэмжээ, ажилласан цагт нь тохирсон цалин хөлсийг тухай бүр тооцож олгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нэр бүхий ажилтнуудад илүү олгосон хоол, унааны нийт 216000.00 /хоёр зуун арван зургаан мянга/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын авто замын сангийн захирал Р.Буд, нягтлан бодогч Ц.Мөнхтуяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

АШИД БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Д.БОЛОР-ЭРДЭНЭ

Д.ГАНДОЛГОР

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.

[illegible]

[illegible]